

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/129/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Ч.Мөнхтогтох Утас: 70453799, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

УЛААНГОМ СУМЫН СОЁЛЫН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ Ч.БАТБААТАР
ТАНАА

2022.02.25 № УВА-2022/129/НА-СТА-ТМЗ
танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаангом сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.БАТСУУРЬ

0200200208

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>15,630,134.00</u>	<u>15,913,600.00</u>
33	АВЛАГА	316,534.00	
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	136,613.00	
335	Бусад авлага	179,921.00	
3352	Хувь хүмүүсээс авах авлага	179,921.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	15,313,600.00	15,913,600.00
35110	Тусгай зориулалттай материал	4,000,000.00	4,000,000.00
35400	Хангамжийн материал	11,313,600.00	11,913,600.00
35410	Бичиг хэргийн материал	27,500.00	112,500.00
35420	Аж ахуйн материал	46,000.00	46,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал	400.00	400.00
35470	Бусад хангамжийн материал	11,239,700.00	11,754,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>643,683,592.63</u>	<u>635,445,051.67</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	643,683,592.63	635,445,051.67
39100	Газар		
39200	Биет хөрөнгө	618,947,592.59	610,809,051.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	618,100,100.00	618,100,100.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-29,197,430.08	-43,388,845.12
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	63,838,952.00	75,338,752.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-43,735,351.34	-53,942,707.30
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,817,700.00	9,047,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,289,535.99	-7,071,305.99
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,400,000.00	2,400,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,890,000.00	-2,070,000.00
39300	Биет бус хөрөнгө	24,736,000.04	24,636,000.08
39301	Програм хангамж	500,000.00	500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-99,999.96	-199,999.92
39303	Бусад биет бус хөрөнгө	24,336,000.00	24,336,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>659,313,726.63</u>	<u>651,358,651.67</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	145,591.00	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	145,591.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	659,168,135.63	651,358,651.67
51	Засгийн газрын хувь оролцоо	659,168,135.63	651,358,651.67
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	639,621,454.00	639,621,454.00
51200	Хуримтлагдсан үр дүн	-53,525,348.67	-61,334,832.63
51210	Өмнөх үеийн үр дүн	-53,525,348.67	-53,525,348.67
51220	Тайлант үеийн үр дүн		-7,809,483.96
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	73,072,030.30	73,072,030.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>659,313,726.63</u>	<u>651,358,651.67</u>

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Балансын үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	70,412,700.00	126,985,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,412,700.00	126,985,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,900,000.00	1,230,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,900,000.00	1,230,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	9,900,000.00	1,230,000.00
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	60,512,700.00	125,755,400.00
122005	Төсвөөс санхүүжих	60,512,700.00	125,755,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	00.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	63,311,609.12	134,794,883.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	63,311,609.12	134,794,883.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,311,609.12	131,365,090.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,077,228.00	83,665,935.00
210101	Үндсэн цалин	30,746,728.00	64,635,638.00
210105	Гэрээт цалин	12,330,500.00	19,030,297.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,582,467.00	10,941,377.00
210201	Тэтгэврийн даатгал	3,785,038.00	7,678,127.21
210202	Тэтгэмжийн даатгал	446,457.00	851,113.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	357,326.00	681,070.79
210204	Ажилгүйдлийн даатгал	100,431.00	157,542.37
210205	Эрүүл мэндийн даатгал	893,215.00	1,573,523.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,431,107.00	6,463,027.13
210301	Гэрэл, цахилгаан	230,107.00	682,027.13
210302	Түлш, халаалт	3,187,500.00	5,659,500.00
210303	Цэвэр, бохир ус	13,500.00	121,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,000.00	1,449,050.00
210401	Бичиг хэрэг		161,750.00
210402	Тээвэр, шатахуун		172,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		275,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		195,300.00
210408	Бараа материал акталсны зардал		645,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,426,200.00
210604	Урсгал засвар		2,426,200.00
2107	Томилолт, зочны зардал		120,000.00
210702	Дотоод албан томилолт		120,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	501,360.00	838,960.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		179,600.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	60,000.00	216,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	198,000.00	200,000.00
210807	Газрын төлбөр	243,360.00	243,360.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,689,447.12	25,460,540.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,689,447.12	25,460,540.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,429,793.87
2132	Бусад урсгал шилжүүлэг		250,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		250,000.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		3,179,793.87
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		3,179,793.87
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	7,101,090.88	-7,809,483.96
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	7,101,090.88	-7,809,483.96

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Балансын үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	115,326,900.00	125,755,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	115,326,900.00	125,755,400.00
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	115,326,900.00	125,755,400.00
122005	Төсвөөс санхүүжих	115,326,900.00	125,755,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	115,326,900.00	125,755,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	115,326,900.00	125,755,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	114,276,531.09	122,325,606.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	89,714,187.09	83,494,992.00
210101	Үндсэн цалин	69,237,900.00	64,722,528.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,476,287.09	18,772,464.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,246,900.00	10,941,377.00
210201	Тэтгэврийн даатгал	7,647,800.00	7,678,127.21
210202	Тэтгэмжийн даатгал	899,800.00	851,113.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	686,900.25	681,070.79
210204	Ажилгүйдлийн даатгал	212,899.75	157,542.37
210205	Эрүүл мэндийн даатгал	1,799,500.00	1,573,523.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,380,104.00	6,463,027.13
210301	Гэрэл, цахилгаан	542,104.00	682,027.13
210302	Түлш, халаалт	5,685,000.00	5,659,500.00
210303	Цэвэр, бохир ус	153,000.00	121,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,229,000.00	5,381,250.00
210401	Бичиг хэрэг	310,000.00	201,750.00
210402	Тээвэр, шатахуун	258,100.00	172,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	360,000.00	275,000.00
210404	Ном, хэвлэл	59,000.00	4,492,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	241,900.00	240,300.00
2105	Нормативт зардал	500,000.00	100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	100,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,514,000.00	14,086,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	230,000.00	11,659,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	100,000.00	
210604	Урсгал засвар	3,184,000	2,426,200.00
2107	Томилолт, зочны зардал	238,500.00	120,000.00
210702	Дотоод албан томилолт	238,500.00	120,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,453,840.00	1,738,960.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	128,000.00	1,079,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	60,000.00	216,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	698,000.00	200,000.00
210807	Газрын төлбөр	567,840.00	243,360.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,050,368.91	3,429,793.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	250,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	250,000.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	750,368.91	3,179,793.87
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	750,368.91	3,179,793.87
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	0.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Балансын үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	639,621,454.00	73,072,030.30	-60,923,935.55	651,769,548.75
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	639,621,454.00	73,072,030.30	-60,923,935.55	651,769,548.75
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Өмчид гарсан өөрчлөлт				
8	Зарласан ногдол ашиг				
9	Тайлант үеийн үр дүн			7,101,090.88	7,101,090.88
10	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	639,621,454.00	73,072,030.30	-53,525,348.67	659,168,135.63
11	2021 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	639,621,454.00	73,072,030.30	-53,525,348.67	659,168,135.63
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	639,621,454.00	73,072,030.30	-53,525,348.67	659,168,135.63
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Өмчид гарсан өөрчлөлт				
18	Зарласан ногдол ашиг				
19	Тайлант үеийн үр дүн			-7,809,483.96	-7,809,483.96
20	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	639,621,454.00	73,072,030.30	-61,334,832.63	651,358,651.67

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Балансын үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	125,755,400.00	122,575,606.13	3,179,793.87	97.5%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	125,755,400.00	122,575,606.13	3,179,793.87	97.5%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	125,505,400.00	122,325,606.13	3179793.87	97.5%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	85,942,500.00	83,494,992.00	2,447,508.00	97.2%
210101	Үндсэн цалин	65,206,000.00	64,722,528.00	483,472.00	99.3%
210102	Нэмэгдэл				
210104	Урамшуулал				
210105	Гэрээт ажлын хөлс	20,736,500.00	18,772,464.00	1,964,036.0	90.5%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,602,300.00	10,941,377.00	660,923.00	94.3%
210201	Тэтгэврийн даатгал	8,164,600.00	7,678,127.21	486,472.79	94.0%
210202	Тэтгэмжийн даатгал	859,500.00	851,113.53	8,386.47	99.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	687,500.00	681,070.79	6,429.21	99.1%
210204	Ажилгүйдлийн даатгал	171,900.00	157,542.37	14,357.63	91.6%
210205	Эрүүл мэндийн даатгал	1,718,800.00	1,573,523.10	145,276.90	91.5%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,511,900.00	6,463,027.13	48,872.87	99.2%
210301	Гэрэл, цахилгаан	672,900.00	682,027.13	-9,127.13	101.4%
210302	Түлш, халаалт	5,685,000.00	5,659,500.00	25,500.00	99.6%
210303	Цэвэр, бохир ус	154,000.00	121,500.00	32,500.00	78.9%
2104	Хангамж, бараа материалын зардал	5,382,000.00	5,381,250.00	750.00	100.0%
210401	Бичиг хэрэг	183,300.00	201,750.00	-18,450.00	110.1%
210402	Тээвэр, шатахуун	172,200.00	172,000.00	200.00	99.9%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	275,000.00	275,000.00		100.0%
210405	Ном, хэвлэл	4,550,000.00	4,492,200.00	57,800.00	98.7%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	201,500.00	240,300.00	-38,800.00	119.3%
2105	Нормативт зардал	100,000.00	100,000.00		100.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	100,000.00		100.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,093,200.00	14,086,000.00	7,200.00	99.9%
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,667,000.00	11,659,800.00	7,200.00	99.9%
210604	Урсгал засвар	2,426,200.00	2,426,200.00		100.0%
2107	Томилолт, зочны зардал	134,500.00	120,000.00	14,500.00	89.2%
210702	Дотоод албан томилолт	134,500.00	120,000.00	14,500.00	89.2%

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,739,000.00	1,738,960.00	40.00	100.0%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,079,600.00	1,079,600.00		100.0%
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	216,000.00	216,000.00		100.0%
210806	Мэдээллийн технологийн зардал	200,000.00	200,000.00		100.0%
210807	Газрын төлбөр	243,400.00	243,360.00	40.00	100.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	250,000.00	250,000.00		
2132	Бусад урсгал шилжүүлэг	250,000.00	250,000.00		100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	250,000.00		100.0%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	125,755,400.00	122,575,606.13	3,179,793.87	97.5%
	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	125,755,400.00	122,575,606.13	3,179,793.87	97.5%
122005	Төсвөөс санхүүжих	125,755,400.00	122,575,606.13	3,179,793.87	97.5%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	0.00	0.00	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	0.00	0.00	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаангом сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улаангом сумын Соёлын төв нь “Соёлын үнэт зүйлийг өвлөн хамгаалж, түгээн дэлгэрүүлж бүх нийтэд соёл урлагийн боловсролыг эзэмшүүлж, авьяас билгийг нээн хөгжүүлнэ. Орон нутгийн болон аймаг бүсийн хэмжээнд соёл урлагийн үйлчилгээг иргэдэд хүргэж Соёлын өв уламжлалыг хүүхэд залуучуудад сурталчлан таниулж, өвлүүлэн үлдээхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 1,105.0 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 134,794.8 мянган төгрөгийн 1 хувь буюу 1,347.9 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 1,078.3 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Улаангом сумын Соёлын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 651,358.6 мянган төгрөг буюу 1.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	15,313.6	15,913.6	600.0
Үндсэн хөрөнгө	643,683.6	635,445.0	-8,238.6
Нийт хөрөнгө	659,313.7	651,358.6	-7,955.1
Өр төлбөр	145.5	0.0	-145.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	659,313.7	651,358.6	-8,238.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	659,313.7	651,358.6	-7,955.1

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 15,913.6 мянган төгрөг болж 600.0 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан бичиг хэргийн материал зарцуулагдаагүй үлдсэн байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 635,445.0 мянган төгрөг болж 8,238.6 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансанд 17,222.0 мянган төгрөгөөр тоног, төхөөрөмж худалдан авсан хэдий ч тайлант жилийн элэгдлийн зардал 25,460.0 мянган төгрөг болж нийт хөрөнгө 8,238.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 651,358.6 мянган төгрөг болж 8,238.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ. Энэ нь үр дүн алдагдалтай гарсантай холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 7,770.0 мянган төгрөгөөр буюу 87.6 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна. Энэ нь үндсэн хөрөнгө нэмэгдсэн, бараа материал авсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 21,855.1 мянган төгрөгөөр буюу 17.0 хувиар өссөн байна. Энэ нь үндсэн хөрөнгийн элэгдэл, түлш халаалт, эд хогшил, урсгал засварын зардлууд өссөнтэй холбоотой байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Улаангом сумын Соёлын төвийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 143,714.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 143,714.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 17,959.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 125,755.4 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь өмнөх төсвийн хэмнэлтийг нэмж олгосонтой холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 125,755.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 125,755.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 125,755.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 122,325.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 122,325.6 мянган төгрөг буюу 97.5 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн нэмэлт санхүүжилтийн данс байхгүй болно.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Улаангом сумын Соёлын төвийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2020 оны санхүүгийн тайлангаар зөвлөмж өгсөн тул А/108 дугаар тушаалаар өгсөн ерөнхий чиглэлийн хавсралт 1 маягтаар нарийвчилсан горим хэрэгжүүлэхэд зөрчил илрээгүй болно.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 151, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд нь байршуулах зөвлөмжийн хэрэгжилтийг Улаангом сумын Соёлын төвийн даргын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТЦУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  /Ч.МӨНХТОГТОХ/

2022 оны 02 сарын 14-ний өдөр